

ГАРЧИГ

ОРШИЛ.....	2
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	5
ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
Тухайн бүс нутагт 0,7-0,8 хүн/км ² ногдож хүн ам сийрэг оршин суудгаас гадна, ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий талбай нь уулын бүсэд байх тул хүнгүй зэлүүд газар юм.....	Error! Bookmark not defined.
ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26
НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	29
ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	34
АРАВ. А.....	37
АРВАННЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	37
АРВАНХОЁР. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	Error! Bookmark not defined.
ТОЛГОЙТЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ, ЗАРДЛЫН ЗАДАРГАА.....	38

ОРШИЛ

“Ди Зэт Энд Ай” ХХК-ний Сэлэнгэ аймаг Ерөө сумын нутагт орших “Толгойтын алтны шороон ордыг ашиглах” төсөл нь MV-000168 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 202.34 гектар талбайд үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол орны 1:100 000 байр зүйн зургийн номенклатурын М-48-95-р хавтгайд байрлана. Уг төсөл нь Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Засгийн газар, Байгаль орчны болон бусад холбогдох яамнаас гаргасан зохих заавар журмуудыг мөрдөн ажиллаж байна.

Тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд /БОМТ/ төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчин болон хүмүүст нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эсрэг авах урьдчилан сэргийлэх болон бууруулах арга хэмжээнүүд, нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр /ОХШХ/ зэрэгт шаардлагатай зардал, хугацаа давтамж, мөрдөж ажиллах хууль тогтоомж стандартуудыг тусгалаа.

“Ди Зэт Энд Ай” ХХК нь MV-000168 тоот тусгай зөвшөөрөл бүхий табайн ХШ-64, ХШ-1/27, ХШ-68, ХШ-2/32 хайгуулын шугамууд хооронд хайгуулын ажил явуулж, хайгуулын ажлын үр дүнгийн тайланг боловсруулан бичиж улмаар 2018 оны 3 дугаар сарын 21-нд АМГ-ын Геологи судалгааны хэлтэс, ЭБМЗ-р 3 блок талбайд 580.58 мян.мЗ элс, химийн цэврээр 60.58 кг алтны нөөцийг бүртгүүлсэн байдаг. Толгойтын алтны шороон ордод хийгдсэн хайгуулын ажлын үед олон жилийн цэвдэг илрээгүй нь ордыг ил аргаар олборлох таатай нөхцөлийг бүрдүүлж байна.

Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, үргэлжлэх хугацаа зэргийг орон зайн мэдээллийн загварчлалыг ашиглан боловсруулж тусгалаа.

“Ди Зэт Энд Ай” ХХК-ний 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 дугаар журмын дагуу боловсрууллаа.

НЭГ. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ашигт Малтмалын Газраас “Ди Зэт Энд Ай” ХХК-д Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт дахь “Толгойт” нэртэй газарт орших 202.34 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг анх 2007 олгож MV-000168 дугаар бүхий гэрчилгээг 2007 оны 01 сарын 29-ний өдөр олгосон байдаг. Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг даргын 2020 оны 4-р сарын 8 –ний өдрийн 000018082 тоот дугаартай Ашигт малтмал олборлох зориулалтаар ашиглах газрын гэрчилгээтэй.

ЭБЭХЯ-ны дэргэдэх АМГ-ын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2018 оны 03 сарын 21 -ны өдрийн хурлын хуралдааны ХХ-02-08 дугаар дүгнэлтийг үндэслэн (Ордын нөөц 2017 оны 11-р дугаар сарын 01-ны байдлаар) Толгойт нэртэй MV-00168 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдах алтны үүсмэл ордын бодитой (В) нөөцийг 580.58 мян.м³, алтны нөөцийг 60.58 кг (химийн цэврээр) хүлээн авсан байна.

2025 оны уулын ажлын төлөвлөгөөнд заасан хөрс хуулалт, элс олборлолтын хэмжээ болон гүйцэтгэлийг 2025 оны 10 сарын 20-ны байдлаар хүснэгт-1-т үзүүлэв.

Хүснэгт-1. Уулын ажлын төлөвлөгөө болон гүйцэтгэл.

д/д	Үзүүлэлт	Уулын ажлын төлөвлөгөө	Гүйцэтгэл	%
1	Уулын цул, мян.м ³	244.5	244.5	
2	Хөрс хуулалт, мян. м ³	119.5	119.5	
3	Элс олборлолт, мян. м ³	125.0	125.0	
4	Алт олборлолт.кг	12.2		

Дэд бүтэц, зам харилцаа: Тус орд газар нь Сэлэнгэ аймгийн Ерөө сумын нутагт Баянгол болон Булаг голын бэлчир орчим Дархан хотоос зүүн хойш 120 км, Сүхбаатар хотоос зүүн урагш 200 км, Ерөө сумын төвөөс зүүн урагш 30 км, Бугант суурингаас баруун урагш 20 км-д байрлана. Толгойтын алтны бүлэг ордыг ашиглах үед Бугант тосгон, эмнэлэг, сургууль, 110 кВт-ын цахилгааны өндөр хүчдэлийн шугам, автомашины сайжруулсан зам зэргийг барьж байгуулснаар дэд бүтцийн гол гол асуудлууд бүрэн шийдэгдсэн байдаг.

Уурхайд дараах дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг хийгээд байна. Үүнд: Уурхайд ажилчдын хотхон, цайны газар, амрах байр, дууш саун, оффис, амрах байр, засварын газар зэрэг барилга байгууламжууд, цахилгаан хангамж, ус хангамж, зам талбай зэрэг уурхайн дэд бүтцийг бүрэн шийдсэн. Мөн олборлолтын болон элс угаан баяжуулах цехийн тоног төхөөрөмжүүд, ажиллах хүчнээр бүрэн хангагдсан.

Ил уурхайн үйл ажиллагааны тухай: Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаа нь ухаж ачих, хөрс болон элс тээвэрлэлт, овоолго гэсэн дэс дараатайгаар явагдана. Тайлант онд шинээр карьер болон овоолгын тэлэлт байхгүй.

Ажиллах хүчний тухай: Тайлант онд 62 хүн ажилласан.

Уурхайд ажиллуулах техник тоног төхөөрөмж: Толгойтын алтны шороон ордын төв хэсгийн үүсмэл ордыг ил уурхайн аргаар олборлохоор төлөвлөсөн. Уурхайд ажиллуулах техник, тоног төхөөрөмжийн сонголтыг БНХУ-н уул уурхайд өргөн

хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжүүдийг техникийн үзүүлэлт, үнэ, ашиглалтын гол зардал, хүчин чадал зэрэг үзүүлэлтүүдийг үндэслэн сонгосон.

Хүснэгт-2. Уурхайд ашиглаж буй техник

Д.Д	Ашиглагдаж буй тоног төхөөрөмж	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Экскаватор	Ш	3
2	Бульдозер	Ш	3
3	Автосамосвал	Ш	7
6	Усны машин	Ш	1
7	Түлшний машин	Ш	1
8	Land cruiser	Ш	1
9	Хутгуурт ачигч	Ш	2

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт-2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл.

№	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Төлөвлөөний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Төлөвлөгөө мян/төг	Гүйцэтгэл мян/төг
Агаар орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авсан арга хэмжээ				
1	Цаг уурын урьчилан сэргийлэх мэдээг үйл ажиллагаандаа тогтмол ашиглах		150	72.0
2	Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг шинжлүүлэх /TSP, PM10, PM 2.5 /	Агаарын бохирдуулагч эх үүсвэрүүдэд агаарын тоосжилтын хэмжилтийг СУЦУОШГазарт хийлгэсэн бөгөөд МУ-ын стандартаас хэтэрсэн үзүүлэлт илрээгүй.	ОХШХ-т тусгав.	
3	Агаарын бохирдолын шинжилгээг хийлгэх / SO2, NO2 , /	4.1км урттай замыг нийт 640м3 ус ашиглан усалсан байна.		
4	Дотоод болон гадаад тээвэрлэлтийн замыг тогтмол услах	Гадаад болон дотоод тээвэрлэлтийн замыг 2 усны машинаар 9-10 дугаар сарын хугацаанд 7 хоног зам талбайн усалгааг хийж ажиллалаа.	ҮАЗ	
5	Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах	Зам талбайг техник хэрэгсэлд тохиромжтой байдлаар засч дагтаршуулах ажлын хүрээнд уурхайн техникийн паспортод үндэслэж тээврийн замыг стандартын дагуу засч янзалсан.		
	ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДҮН		72.0	
Газрын Гадарга болон хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ				
6	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж хадгалах	Толгойтын уурхай 1978 оноос уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн газар тул эрүүл газар шиг шимт хөрсөөр бага байсан хэдий ч бид 2025 оны тайлант онд	ҮАЗ	

		олборлосон блокын шит хөрсийг журмын дагуу хадгалж техникийн нөхөн сэргээлтэнд ашигласан. Төлөвлөгөөт онд 1055м3 шимт хөрсийг хуулж, 1-н талбайд түр овоолгыг MNS 5916:2008 дагуу хуулж, 2м-ээс дээшгүй өндөртэй байхаар зохион байгуулж ажилласан.		
7	Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахгүй байх, замыг тэмдэгжүүлэх	Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гарахаас сэргийлж замын маршрутыг батлуулан, тэмдэг тэмдэглэгээг байршуулж ажиллав. Гадаад болон дотоод тээврийн зам дагуу, машины зогсоолд тус тус байршуулсан.	100	120
8	Хөрсний хяналтын цэгүүдийг уурхайн нөлөөллийн бүсийн хэв шинжээс хамааруулж байгуулах	Уурхайн нөлөөллийн бүсийн хэв шинжээс хамаарч хөрсний хяналтын цэгийг байгуулж, тэмдэгжүүлсэн бөгөөд агрохими болон нефтийн бүтээгдэхүүнийг тодорхойлуулах шинжилгээг СУЦУОШГ-аар хийлгэсэн. Хөрсний хяналтын 4 цэгийг шинээр байгуулж, шимт давхаргуудыг шинжлүүлсэн.	200.0	ҮАЗ
ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДҮН			1200.0	
Газрын гадаргын доорхи усанд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ				
9	Ус ашиглах дүгнэлтийг “Усны газраар гаргуулж ажиллах ”	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газраар 2025 онд ашиглах усны дүгнэлтийг гаргуулж , Хараа-Ерөө голын сав газрын захиргаагаар ус	845.0	845.0

		ашиглуулах тушаал гаргуулж гэрээ хийж ажилласан .		
10	Ус ашигласны төлбөр төлөх	Хараа-Ерөө голын сав газрын захиргаагаар ус ашиглуулах тушаал гаргуулж гэрээ хийж ажилласан гаргуулж усны нөөц ашигласны төлбөр болох 125,513,696.06 төгрөгийг төлж ажилласан	125,513,696.06	125,513,696.06
11	Тунгаагуур нуурууд болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй усны эх үүсвэр зэргээс тогтмол хугацаанд дээж авч бохирдлыг хянан ажиллах замаар сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх	Тунаах нуур болон уурхайн унд ахуйн усны шинжилгээг 2 удаа авч шинжлүүлсэн үзүүлэлтийг итгэмжлэгдсэн лабораториор төлөвлөгөөт оны 7, болон 9сард шинжлүүлсэн бөгөөд МУ-ын стандартаас давсан үзүүлэлт байгаагүй.	ОХШХ-т тусгав.	
ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДҮН			126,478,696	
Ургамлан бүрхэвчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн эсрэг авсан арга хэмжээ				
13	Ургамалын мониторингийн цэгийн хэмжилт хяналт, мэдээллийн сан үүсгэж ажиллах	Ургамалжилтийн хэв шинжээс хамаарч ургамлын хяналтын 3 цэгийг шинээр байгуулсан. Толгойтын уурхайн нийт ургамлан бүрхэвчийн 95% нь уулын ойт хээр, 5% нь уулын хээрийн нуга төрөл эзэлнэ. Ургамлын хяналтыг 3 цэгт хийдгээс нөлөөллийн бүсэд 1, нөлөөллийн бүсийн ойролцоо 1, нөлөөллийн бүсээс хол 1 цэг сонгож бүртгэлжүүлэн, 5-8 дугаар сард нийт 9 удаагийн судалгааг хийж ажиллаж байна.	ҮАЗ	

ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДҮН		
Амьтны аймгийн чиглэлээр авсан арга хэмжээ		
14	Лизензийн талбай болон Дүйцүүлэн хамгааллын талбайн зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан амьтанд судалгаа хийж мэдээллийн сан үүсгэж ажиллах, Ерөө сумын ЗДТГазар болон байгаль орчны албанаас зөвлөгөө авах.	Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүний буруутай үйл ажиллагаанаас улбаалан амьтад даажих нөлөөллөөс сэргийлж уурхайн нөлөөллийн бүсэд МУИС-ийн Өвөрзайсан сургалт судалгааны төвөөр зэрлэг амьтдын хээрийг судалгааг хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан. Тайлант оны 9/8-9/27 хүртэлх 18 хоног.
ЗАРЦУУЛСАН ЗАРДЛЫН ДҮН		
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭНД ЗАРЦУУЛСАН НИЙТ ЗАРДАЛ		Дүйцүүлэн хамгааллын зардалд тусгав.
		Төлөвлөгөөгөөр /мян.төгрөг /
		Гүйцэтгэлээр /мян.төгрөг /
		3245.0
		5362.0

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Агаар орчны чиглэлээр хийгдсэн ажлууд:

1. Тайлант онд 06.01-10.30 хүртэл буюу 5 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулсан. Цаг уурын урьдчилсан 3 цагаас 5 хоногийн өдөр тутмын мэдээг ЦУОШГ-ын албан ёсны цахим хуудсаас авч өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байлаа.



Зураг- 1 Ерөө сумын цаг агаарын станцын урьдчилсан мэдээ

2. 2025 онд Толгойт уурхай орчны хяналт шинжилгээний хүрээнд агаарын тоосжилтийн хэмжилтийг СЭЛЭНГЭ ЦЭНГЭГ УС ОНӨААГазраар 9 дүгээр сард хийлгэж ажиллаа. Тус шинжилгээгээр MNS4585:2016 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлагын хүлцэх агууламжаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна. Дэлгэрэнгүйг ОХШХ-өөс харах
3. Толгойт уурхай нь өнөөгийн байдлаар үйлдвэрлэлийн технологит шүүрлийн ус ашигладаг бөгөөд шүүрлийн усыг 1.1 км урт 10 м өргөн тээврийн зам дагуу тоосжилт дарах зорилгоор 9 дүгээр сард 160 м³, 10 дугаар сард 180 м³ усыг тус тус нийт 18 удаагийн давтамжтайгаар 288 м³ усыг ашигласан байна.



Зураг- 2 Зам усалгаа хийгдэж буй байдал



График 1 Зам усалгаанд ашигласан усны хэмжээ


- Уурхайн технологийн болон тээврийн замыг техник хэрэгсэлд тохируулан стандартын дагуу засч дагтаршуулж ажилласан. Тээврийн замыг техникийн паспортод заасан байдлаар засч янзалсан болно. Замын өргөн нь тоног төхөөрөмжийн овор хэмжээнээс хамаарч 1 зурвастай байх замын өргөн 3.0 м, хөдөлгөөний 2 зурвастай байх автозамын өргөнийг 6 м, налууг 6° байхаар тооцож үйл ажиллагаа явуулж байлаа.



Зураг- 3 Техникийн паспорт

Хөрсөн бүрхэвч хамгаалах чиглэлээр:

1. Уулын ажлын хүрээнд 2025 онд нийт 10,355м³ шимт хөрсний 1 овоолгийг үүсгэн ажилласан. Шимт хөрс хуулах ажлыг MNS 5914:2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу зохион байгуулж ажилласан ба үржил шимт хөрсийг 20-40см хүртэлх зузаанаар хуулсан байна.




Зураг- 4 Толгойтын уурхайн шимт хөрсний овоолго

2. Авто тээврийн хэрэгслийг тогтсон маршрутаар зорчих, олон салаа зам гаргахаас сэргийлэх, хөрсөн бүрхэвчийг хамгаалах зорилгоор замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан бөгөөд нийт 1.1км хүдэр тээвэрлэлтийн замтай.



Зураг- 4 Авто тээврийн хэрэгслийн замын маршрут



Зураг- 5 Авто тээврийн хэрэгслийн замын тэмдэг тэмдэглэгээ

3. Хүний буруутай үйл ажиллагаанаас болж хөрсний элэгдэл, эвдрэл, доройтлыг бууруулах, үржил шимт давхаргыг хамгаалж уурхайн нөлөөллийн бүсэд нийт 4 цэгийг хөрсний хэв шинжээс хамаарч сонгон, судалж ажилласан. Хөрсний агрохимийн шинж чанарын үзүүлэлтүүдийг Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-ийн байгаль орчны шинжилгээний лабораторид шинжилгээнд өгөх ажлыг зохион байгуулж ажиллав. Нийт 5 үзүүлэлтийг шинжлүүлж ажилласан нь ялзмаг, урвалын орчин (pH), кальцийн карбонат (CaCO_3), хөрсний механик бүрэлдэхүүн, цахилгаан дамжуулалт (ЕС) зэрэг болно. Толгойт уурхайн хөрсийг уулын ба ойн, нуга намаг, голын татам, хуурай сайрын хэмээн 6 ангилна. Хөрсний элэгдэл эвдрэлийн хувьд Толгойтын уурайн бүс нутаг нь Монгол орны хөрс газарзүйн мужлалаар Хангай – Хэнтийн уулархаг их муж ойт хээрийн дэд мужид хамрагдах ба Уулын хээр ой тайгын хөрс нь үржил шим сайтай ургамлын бүрхэц 70-100% байдаг тул хөрсний ус, салхиар элэгдэх эвдрэлт өртөгдөх байдал бага байна. Уурхайлалтын үед карьер, отваль, технологийн зам дагуу хүний үйл ажиллагааны нөлөөллөөр хөрс салхиар элэгдэх өндөр магадлалтай ч одоогоор доройтолд орсон, хөрсний өнгөн үе нь элсжиж, хуурайшсан доройтлыг илэрхийлэгч ургамлууд хуримтлагдсан газар байхгүй. Үүний бас нэгэн нотолгоо нь Толгойтын

уурхайн ургамлан бүрхэвчийн 79% мезофит буюу чийгшсүү ургамалжилттай байгаа нь хөрсөнд агуулагдах чийгийн хэмжээ сайн, ксерофит буюу хуурайсаг ургамлууд зарим тохиолдолд орчны доройтлыг илэрхийлэх боломжтой, 13%-ийг тус тус эзэлж байна. Хөрсний хяналтын 3 дугаар цэг IS-KHG SL 22/03 хөрсний чийгийн хувьд хамгийн их, В давхаргын чийглэг 22.8 – 60г хүртэл, С давхаргын чийглэг 40,7 – 61,9г хүртэл их байна. Харин хяналтын 4 дүгээр цэг бусад хяналтын цэгүүдтэй харьцуулахад чийглэгийн хэмжээ 30 – 79г-р бага байсан ба ургамлан бүрхэвчийн хувьд 100% боловч ксерофит буюу хуурайсаг ургамал бусад хяналтын цэгүүдэд байгаа ксерофит ургамлын төрлөөсөө бага зэрэг их байсан нь ажиглагдав.

Гадаргын доорх усны чиглэлээр:

Толгойтын уурхайн унд ахуйн ашиглалтын худгийн усыг тайлант онд 2 удаа шинжилгээ авж ажиллаж байна.




График 2 Унд ахуйн усны хэрэглээ болон ус ашиглах дүгнэлт

2025 онд Хараа-Ерөө голын сав газрын захиргааны ус ашиглуулах дүгнэлтийн хүрээнд ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээг БОНХАЖЯ сайдын 2015 оны А/301 тоот тушаалаар батлагдсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны норм”-ын дагуу 4.0 м3-аар тогтоосон ба энэхүү хэрэглээ нь ТЭЗҮ-д заасан 31 хүний хоногт ашиглах усны хэмжээгээр тооцогдсон. Тайлант онд Толгойтын уурхайд нийт 32 хүн ажилласан бөгөөд унд ахуйн усны хэрэглээнд 10-12 сард 837 м3 ус ашигласан үзүүлэлттэй байв.

Амьтны аймгийн чиглэлээр:

Уурхайн үйл ажиллагааны улмаас амьтдын амьдрах орчин хумигдах, хүн болон автомашины хөл хөдөлгөөн, дуу чимээнээс амьтад дайжих зэрэгтэй холбоотойгоор нөлөөллийн бүсэд зэрлэг амьтан, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан амьтдын судалгааг “МУИС-ын Өвөрзайсан сургалт, судалгааны төв”-өөр 2025/09/08 – 2025/09/27-ны өдрүүдэд хийлгэх ажлыг зохион байгуулав.

- Зэрлэг амьтдын судалгааны үр дүнд нөлөөллийн бүсэд нийтдээ 55 зүйлийн хөхтөн амьтад тархжээ. Эдгээрийн дотроос 47 зүйл нь энэ бүс нутагт төдийгүй Монгол орны нутагт өргөн тархацтай, тоо толгойн хувьд элбэг тохиолдох зүйлүүд байна. Гэхдээ эдгээр амьтдын дотор тооны хувьд элбэг боловч амьдрах орчин нь хязгаарлагдмал, заавал ус чийгтэй орчныг шаарддаг зэрэг экологийн нарийн зохилдлогоотой (экологийн ниш) амьтад байна. Тухайлбал, Хүснэгт 1-д байгаа атаахайн 5 зүйл, усч гэрэлзгэнэ зэрэг нь зөвхөн усан болон чийглэг орчинд амьдардаг онцлогтой учраас тоо толгойн хувьд элбэг мөртлөө эмзэг байдаг. Мөн монгол тарвага, халиун буга, зэрлэг гахай зэрэг амьтад нь хүний үйл ажиллагаа, хууль бус агнуурт өртөмхий учраас бид энэ бүс нутгийн эмзэг амьтад гэж үзсэн болно.
- Ойн шувуудын бүртгэлийг 2025/09/09-11-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Бүртгэл хийхдээ Bresser брендийн 10x42 харьцаатай дуран мөн шувуудын зургийг Canon 7D mark II камер ашиглан баталгаажууллаа. Нийт 6 баг, 12 овгийн 24 төрлийн 27 зүйл шувуу бүртгэсэн. Эдгээр шувуудыг монгол оронд оршин амьдрах хэлбэрээр нь авч үзвэл 33% (n=9) нь өндөглөн зусдаг, 67% (n=18) нь суурин амьдралтай шувууд байна (Хүснэгт 1). Харин олон улсын байгаль хамгаалах холбооны улаан дансны ангиллаар (IUCN red list, 2001) олон улсын улаан дансанд ховордож болзошгүй гэсэн зэрэглэлд 1 зүйл шувуу багтсан байна
- Шавьжны судалгаагаар нөлөөллийн бүсэд нийт 36 төрлийн 41 зүйлийн шавьж бүртгэгдсэн байна.



Зураг- 6 Толгойт уурхайн нөлөөллийн бүсэд зэрлэг амьтдын судалгааны ажил хийгдэж байгаа нь

Толгойтын уурхайн үйл ажиллагааны явцад сар бүрийн баасан гарагт амьтны хяналтын ажлыг зохион байгуулдаг. Амьтны туурай, саврын мөрөөр ойр орчмын модонд хяналтыг камерыг суулгаж хөдөлгөөнийг ажигладаг. 2025 оны 8 дугаар сараас 11 дүгээр сар хүртэл нийт 3 төрлийн зэрлэг амьтан ажилагсадын утасны камерт бичигдэж үлдсэн байна. Төслийн бүс зэрлэг амьтан амьдрах таатай орчинтой, ургамалжилтын мужлалаар Өвөр байгалийн мужийн баруун хойд Хэнтийн хошуунд хамаарах бөгөөд нарс, хус, улиангаран ойтой, өвсөн тэжээлт амьтдын гол идэш болох үетэн алаг өвс ургана.

Хүснэгт- 1 Зэрлэг амьтдын бүртгэл

Амьтны бүртгэл						
№	Огноо	Амьтны төрөл	Баг	Овог	Зүйл	Латин нэр
1	3/31/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
2	4/04/2023	Хөхтөн	Махчтан	Чоныхон	Саарал чоно	Canis Lupus
3	4/06/2023	Хөхтөн	Махчтан	Чоныхон	Хярс үнэг	Vulpes corsac
4	5/02/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
5	5/18/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
6	5/19/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
7	7/11/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
8	9/19/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Халиун Буга	Cervus Elaphus
9	9/20/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus
10	9/23/2023	Хөхтөн	Салаа туурайтан	Бугынхан	Бор гөрөөс	Capreolos pygargus

- Бор гөрөөс (Capreolos pygargus) биеийн урт 127-137см, жин 28-40кг. Өнгө зүс нь улирлаар солигдох ба идэш тэжээлд нь өвслөг болон модлог ургамал зонхилно.Толгойтын уурхайн бүсэд элбэг тохиолддог (Зураг 8).



Зураг- 7 Бор гөрөөс

- Саарал чоно (Canis Lupus) махан идэшт, биеийн урт 90-160см, сүүлийн урт 33-51 см, 80кг хүртэлх жинтэй байдаг. Нас бие гүйцсэн чоно өдөрт дунджаар 9кг мах иддэг ба дунджаар 6-8 жил амьдарна. Төслийн талбайд ховор тохиолдоно.



Зураг- 8 Саарал чоно (зүүн хойд ууланд)

- Хярс үнэг (Vulpes corsac) биеийн галбир, төрхөөрөө үнэгтэй төстэй боловч илэрхий жижиг биетэй, биеийн өнгө хул шаргалдуу саарал, сор үсний үзүүр цагаан тул мөнгөлөг туяатай харагдана. Биеийн урт 50 – 60см, сүүлний урт 25 – 36см, биеийн жин 2 – 3кг байдаг. Хандгайт уурхайн бүсэд ховор тохиолдоно.



Зураг- 9 Хярс үнэг

- Халиун буга нь бугын төрлийн хамгийн том биетэй зүйл бөгөөд эр бугын сэрвээний өндөр 140-165см, биеийн урт 213-247см, сүүл 7-13см, бор халиун зүстэй. Дайр буюу эр буга хосоор 12 салаалсан том сэргэр эвэртэй, 7кг хүртэл жинтэй. Толгойтын уурхайн бүсэд 9 дүгээр сард үзэгдэнэ.



Зураг- 10 Халиун буга

Толгойтын уурхайн нөлөөллийн бүсэд амьдардаг зэрлэг амьтдын дотоод орчныг тэнцвэржүүлэх, тарга хүч, дархлааны тогтолцоог сайжруулах зорилгоор 100% байгалийн эрдэс бодисоор баялаг органик бүтээгдэхүүнийг “Ашигт Фүүд” ХХК-аас 500кг хэмжээтэйгээр худалдан авч, зэрлэг амьтдын жим, мөр ихтэй, уст цэгүүдэд байршуулж ажиллав.



Зураг- 11 Ашигт долооц байршуулж байгаа нь

Ургамлан нөмрөгийн чиглэлээр:

Төслийн талбай нь Толгойт голын сав газар нь монгол орны ойн ургамалжилтын мужлалаар Өвөр байгалийн мужийн Баруун хойд Хэнтийн хошуунд хамаарна. Зонхилон ургасан нарс, хус, улиангаран ой нь д.т.д 940 – 1000 метрт ургасан бөгөөд үетэн алаг өвст шинжтэй. Ойн бус талбайд ихэвчлэн торлог, тагийн тавилгана, харгана зэрэг бутлаг ургамал ургасан байна. Нийт ургамлан бүрхэвчийн 95% нь уулын ойт хээр, 5% нь уулын хээрийн нуга төрөл эзэлнэ. Ургамлын хяналтыг нийт 3 цэгт хийдгээс нөлөөллийн бүсэд 1, нөлөөллийн бүсийн ойролцоо 1, нөлөөллийн бүсээс хол 1 цэг сонгож бүртгэлжүүлэн, судалж ажиллаж байна. Ургамлын судалгааг 5 – 8 дугаар сард хийв.

- Ургамлын хяналтын 1 дүгээр цэг (IS-PL 22/01) – 11 овгийн 24 зүйл ургамалтай.



График 3 Ургамлын хяналтын 1-р цэг IS PL 22/01

Экологийн бүлгээр нийт бүрхэцийн 62% нь мезофит буюу чийгшсүү эх газрын бүлэгт хамааралтай. Бүлгэмдэлзүйн хэв шинжээр нугын ургамал зүйлүүдийн зонхилох бүрдлийн 58%-ийг эзэлж байна. Космополит буюу завсрын ургамлын зүйлийн тоо хамгийн бага 4% эзэлж буй нь уурхайн үйл ажиллагаа хөрсний ус чийгийн горимд сөрөг нөлөө үзүүлээгүй илтгэнэ. Түүнчлэн онцгой статусын хувьд 79% элбэг, 21% ховор байлаа.

- Ургамлын хяналтын 2 дугаар цэг (IS-PL 22/02) – 17 овгийн 27 зүйл ургамалтай.




График 4 Ургамлын хяналтын 2-р цэг IS-PL 22/02

Экологийн бүлгээс чийгшсүү – мезофит ургамал 86%, 55% нь нуга, 33% нуга хээрийн ургамал эзэлж буй нь эгэл баврант Хусан ойн бүрдлийг бүрэн хадгалсан хэв шинжит хяналтын цэг юм. Онцгой статусын хувьд 62% элбэг, 38% ховор ургамалжилттай байна.

Бүрхэц 5-р сард – хяналтын цэгийн хөрс чийглэг, хүйтэн, сүүдэрсэг ургаж буй нь ургамлууд тачир, сэргэлт дунд зэрэг боловч 1м/кв байх ургамлын тоо 40-с дээш хээрийн шивлээ зонхилж ургаж байсан тул хаврын сэргэн ургалт сайн, зүйлийн тоо олон 4 баллэлбэгдүү//бодгалийн тооны 30-50 ширхэг.

Бүрхэц 6-р сард – 6 балл – маш элбэг, бодгалийн тооны 70 – аас дээш.

- Ургамлын хяналтын 3 дугаар цэг (IS-PL 22/03) – 15 овгийн 27 зүйл ургамалтай.




График 5 Ургамлын хяналтын 3-р цэг IS-PL 22/03

Экологийн бүлгээр хяналтын IS 22/02 цэгтэй харьцуулахад чийгшсүү – мезофит ургамлууд 3% их, бүлгэмдэлзүйн хэв шинжээр нугын ургамал 4% -иар их байгаа нь Эгэл баврант ягаан сорвоо Улиангар оролцсон, Хусан ойн хөндийн хэв шинжийг илтгэж байна. Онцгой статусын хувьд 58% элбэг 42% ховор төрлийн ургамалжилттай. Толгойтын уурхайн бүсийн хувьд нийт 20 овгийн 53 зүйлийн ургамал байдгаас 66.2% элбэг, 34.8% ховор ургамалтай.

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

№	Төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн талаар хийгдсэн ажлууд	Төлөвлөгөөт мян.төг	Гүйцэтгэл мян.төг
1	MV-00168 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд 7.08 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	MV-00168 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн төв хэсэгт 7.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн	10,000.0	8000.00
2	Биологийн нөхөн сэргээлт 1.5 га талбайд хийх	MV-00168 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн төв хэсэгт 1.5 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн	500.0	ҮАЗ
3	Сэлэнгэ аймгийн хэмжээнд уул уурхайн улмаас эвдэрч олон жил орхигдсон нөхөн сэргээлт хийгдээгүй талбайд техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх	Сэлэнгэ аймгийн Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газраас 2023 оны 4-р сарын 20 өдрийн №239 тоотын дагуу Эвдэрч, сүйдсэн 4.0 га талбайд 18724м3 шорооны ажил хийгдсэн.Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны Их өлөнтийн ам нэртэй газар уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил орхигдсон 4.0 га талбайн дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Бугант нандин” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулсаны дагуу 2023/10/13-2023/10/19-ны хугацаанд хийж гүйцэтгүүлсэн ба 2023/10/28-ны өдөр орон нутгийн комисст хүлээлгэн өгсөн.	5000.0	83,300.0
4	Тэрбум мод хөтөлбрийн хүрээнд хэрэгжүүлэх 1.5 га талбайд	Тэрбум мод хөтөлбрийн хүрээнд хэрэгжүүлэх 1.5 га талбайд Бугант нандин ХХК-р мод тариулсан.	950.0	10000.0
	Нийт зардал		10 00.0	103,100.0

Дүйцүүлэн хамгаалал – Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг “Ди Зэт Энд Ай” ХХК –ний Толгойтын уурхайн гүйцэтгэх захирал Д.Золжавхлан болон “Бугант нандин” ХХК –ний захирал С.Батсүх нарын байгуулсан гэрээний дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны байрших эвдрэлд орсон 4.0 га газарт 2021/08/13- 2021/09/13 – ны өдрийг хүртэл хийж гүйцэтгүүлэн хүлээж авсан. Гүйцэтгэгч нь техникийн нөхөн сэргээлтийн ажлыг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн MNS 5917:2008 стандартын дагуу гүйцэтгэж ажилласан. Гүйцэтгүүлсэн ажлын хөлс НӨАТ-тай 72,000,000 төгрөг. Нөхөн сэргээлтэд нийт 18,724 м3 шорооны ажил хийсэн.





Зураг- 12 Толгойтын уурхай – 8.3 га талбайн техникийн нөхөн сэргээлт

Солбицол /UTM/	Газарзүйн солбицол
673269.081,5484121.8333	49°29'6.40"N 107°23'13.07"E
673288.3348,5483956.0033	49°29'11.97"N 107°23'14.60"E
673080.7583,5483891.4001	49°29'12.13"N 107°23'33.64"E
672942.2883,5483960.6245	49°29'5.93"N 107°23'32.44"E
672842.1322,5484055.7509	
672691.3246,5484125.0177	

Хүснэгт- 2 Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбицол

Солбилцол /UTM/		Газарзүйн солбицол
673531.13	5483771.71	49°29'6.40"N 107°23'13.07"E
673325.75	5483765.99	
673320.38	5483861.58	
673537.84	5483818.93	



Зураг- 14 Толгойтын голын ам – 4.9 га талбайн дүйцүүлэн хамгаалах техникийн нөхөн сэргээлт

Хүснэгт- 3 Дүйцүүлэн хамгаалах ажил хийсэн талбайн солбицол.

Солбицол /UTM/
675254.960, 5484712.890
675212.740, 5484773.360
675309.350, 5484900.10
675397.380, 5484960.200
675626.690, 5485049.400
675628.680, 5484987.650

Мөн уурхайн талбай орчмыг тоосжилтоос сэргийлж, ажилчдын ажиллах орчныг сайжруулах зорилгоор 100 ширхэг нарс модыг ХБҮ-ийн хүлээн авахыг тойруулан тарьсан ба 10 дугаар сард нөхөн тарилт хийж ажилласан.



Зураг- 13 тарьцыг Толгойтын уурхайн инженер техникийн ажилтнууд суулгаж байгаа нь

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлант онд Толгойтын уурхайн нөлөөллийн бүсэд амьдрах зэрлэг амьтдын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулж, цаашлаад жил бүр энэхүү ажлыг зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

- Ширээр тадбай ухах уурхайн үйл ажиллагааг эхлэхээс өмнө нөлөөллийн бүсийг тогтооно. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсанаар нөлөөллийн бүсэд
 - Барилга байгууламж байхгүй
 - Төв суурин газар байхгүй
 - Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн дагуу
- 20 жилээр нэг удаа сунгасан дахин урт хугацаагаар ашиглах ангилалд багтаасан

Иймд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээндий ажил тусгагдахгүй.

ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэхүү талбайд бид 2019 онд археологи, палеонтологийн хайгуул судалгааны ажлыг хийлгэж ажилласан. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн судалгаагаар археологийн түүх соёлын дурсгал илрээгүй юм. Иймд бид 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд түүх соёлын дурсгалт өвийг хамгаалахад ажил тусгаагүй болно. Цаашид монгол улсын хууль тогтоомж дүрэм журмыг мөрдөж дурсгалт зүйл илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагад шат дараатайгаар мэдэгдэж хамгаалах арга хэмжээг авч ажиллах болно.

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт- 4 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.

№	Хийхээр төлөвлөсөн ажлууд	Хийгдсэн ажил	Төлөвлөгөөний төсөв мян.төг	Гүйцэтгэл мян.төг	Тайлбар
1	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журмыг ХАБЭА-н ажилтантай хамтран “Уурхайн галын аюулгүй байдлыг хангах нэгдсэн журам”-ыг боловсруулав. Улаанбаатар хот Налайх дүүрэг дэх ОБЕГ-н харьяа Уул уурхайн аврах ангиар уурхайн онцлогт тохирсон осол аваарийн үеэ авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж ажилласан.	-	-	-
2	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтанд хамруулах	Уурхайн бүх ажилчдын хэмжээнд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилт Толгойтын уурхайд зохион байгуулагдсан. Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилчид тус үйл ажиллагаанд тусгай зориулалтын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнд орж ажиллалаа.	300.0	800	-
3	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байршуулах, гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслүүд болон гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас зэргийг нь Толгойтын уурхайг ХБҮ-ийн талбайд байршуулав.	ҮАЗ	-	-

	хуудас хийж шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газар байрлуулах				
4	Анхааруулга, замын таних тэмдэг тэмдэглээг уурхайн талбай болон шаардлагатай газруудад байрлуулах	Жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлээс машин техник мөргөлдөх, хүн, амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх эрсдийг бууруулж, анхааруулга, замын таних тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан.	200.0	400.00	-
		Нийт	500.0	1200.0	

Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дэлгэрэнгүй тайлан.

1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаарх дүрэм, журмыг ХАБЭА-н ажилтантай хамтран “Уурхайн галын аюулгүй байдлыг хангах нэгдсэн журам”-ыг боловсруулав.
2. Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслүүд болон гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас зэргийг нь Толгойтын уурхайн ШТС-н хашаа болон уурхайн хотхоны оффисын гадна талбайд байршуулав.



Зураг- 14 Галын аюулаас урьдчилан сэргийлэх анхааруулга, хэрэгслүүд

3. Жолоочийн санамсар болгоомжгүй үйлдлээс машин техник мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх, чулуун нурангид өртөх зэргээр гэмтээж бэртээх эрсдлийг бууруулах, анхааруулга, замын таних тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байршуулсан.



Зураг- 15 Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээ

НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт- 5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Төлөвлөгөө /сая. төг/	Хог хаягдлын чиглэлээр хийгдсэн ажил	Гүйцэтгэл /сая.төг/
1	Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах	Түр хогийн цэг	0.3	Баяжуулах үйлдвэрийн орчмын хог хаягдлыг тогтсон нэг цэгт ангилан ялгаж, төвлөрүүлэх зорилгоор төмөр суурьтай, салхинд хийсэхээс сэргийлсэн дээвэр бүхий хаалттай хогийн савыг хаягдал төмрөөр хийсэн.	2.0
2	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулалт хийх зорилгоор ангилан ялгалтын хогын сав байршуулах	ХБҮ, Уурхайн суурин	2.0	Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглахын ач холбогдол сэдэвт мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг Толгойтын уурхайн нийт ажилчдад орж ажилласан.	1.8
3	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулах	Уурхай хэмжээнд	0.1	Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулсан.	0.3
Нийт			2.4		4.2

Монгол улсын хог хаягдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм журам стандартуудыг хангуулж, үйлдвэрийн газрын хэмжээнд сахин мөрдүүлэх зорилгоор дотооддоо хог хаягдлын журманд нэмэлт тодотгол оруулан Толгойт уурхайн нийт ажилчдад мэдлэг олгох сургалт зохион байгуулж, журмыг мөрдүүлж ажиллалаа.

Үлэмж Хүдэр ХХК-ийн Толгойтын уурхайтай “Энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булах, устгах болон аюултай хог хаягдал тос, дугуй нийлүүлэх иргэн аж ахуй нэгжтэй хийсэн байгууллага хоорондын гэрээ” -г 2025/07/01 өдөр байгуулсан.

Хог хаягдлын журманд зааснаар төслөөс дараах хог хаягдлууд гардаг бөгөөд түр цуглуулах цэг болон ангилан ялгах хэсгүүдэд цуглуулдаг. Үүнд:

Энгийн, хатуу хог хаягдал – Аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.

Хуванцар, шил, лааз: Энгийн хатуу хог хаягдлыг түр цуглуулах цэгт хуримтлуулан, батлагдсан хуваарийн дагуу 7 хоногт нэг удаа нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг. Хог хаягдлын тээвэрлэлтийн бүртгэлийг талбайн инженер хөтөлдөг. Хуванцар болон шилийг ангилан ялгаж “Үлэмж хүдэр” ХХК-ийн түр цуглуулах цэгт хүргүүлэн ажиллаж байна.

Хаягдал төмөр: Төслөөс гарч буй төмрийг түр цуглуулах цэгт хуримтлуулан овор хэмжээ ихэссэн үед хаягдал төмөр цуглуулах цэгт хапгалдаг. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах зорилгоор хаягдал төмрөөр хашаа, самбар, сандал гэх мэт зүйлсийг хийж дахин ашигладаг.

Хаягдал мод: Төслөөс гарч буй модны хаягдлыг өөрийн мужааны цехэд нийлүүлэх ба эндээс шаардлага хангасан модыг ялган авч цаашид ашиглах бөгөөд шаардлага хангахгүй модны хаягдлыг уурын зууханд түлш болгон ашигладаг.

Хаягдал поошиг: Төслөөс гарч буй хаягдал поошигийг ангилан ялгаж хураан ажилчид болон орон нутгийн иргэдийн хэрэгцээнд 1ш поошигийг 6000 төгрөгөөр үнэлэн зарж борлуулж байна. Дотооддоо хагдал поошигийг түр хогийн цэг, хуванцар сав цуглуулах болон хэсэг нэгжүүдийн засварын талбайд тос маслын асгаралт үүсхэд хэрэглэх үртэс, хужир хийж байршуулах зэргээр эргүүлэн ашиглаж байна.



График 6 Толгойтын уурхайгаас гарсан энгийн хог хаягдлын хэмжээ сар бүр, өссөн дүнгээр

Тайлант онд Толгойтын уурхай нь 06 /01-ээс эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үүнээс өмнө үйлдвэр угсралтын ажил явагдсан тул хог хаягдлын хэмжээ бага байсан бөгөөд сар 1-2 удаа хог ачилт хийлгэх ажлыг зохион байгуулж байгуулж байсан. хийсэн хог хаягдлын гэрээний дагуу 2025 онд нийт 9 удаа 0.51м³ хог хаягдлыг нийлүүлсэн үзүүлэлттэй байна. Манай уурхай хаягдал дугуй, хаягдал төмөр, хуванцар зэргийг дахин ашиглаж, байгаль орчин, дахин сэргээгдэхгүй түүхий эдийн хэрэглээг багасгах, хэлбэр дүрсийг өөрчлөн бүтээлч байдлаар хэрэглэх зорилго тавин ажилладаг.

Аюултай болон хяналттай хог хаягдал: хүн, амьтан болон байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх аюултай шинж чанартай хог хаягдлыг хэлнэ.

Ажилласан тос масло:

Толгойтын уурхай нь Үлэмж хүдэр ХХК-тай 2025 онд байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу гарсан үйлдвэрлэлийн болон аюултай хог хаягдлыг нийлүүлэн ажилласан. Тус онд үйлчилгээний машинаас аюултай хог хаягдлын зэрэглэлд багтах ажилласан тос масло-58л, маслоны шүүр-5ш, түлшний шүүр-3ш гарснаас ажилласан тос маслог түр цуглуулах цэгт шилжүүлсэн ба маслоны шүүр, түлшний шүүрийг замын тэмдэг тэмдэглэгээнд ашиглахаар түр хадгалж байна.

Зураг- 16 Ди Зэт Энд Ай ХХК-ийн Ажилласан тос нийлүүлсэн дагалдах бичиг.

Хүснэгт- 6 Аюултай хог хаягдал

№	Огноо	Техникийн марк	Үйлчилгээ	Аюултай хог хаягдал			Хог хаягдлыг тээвэрлэсэн цэг
				Ажилласан тос масло /л/	Маслын шүүр /ш/	Түлшний шүүр /ш/	
1	2025.07.05	80-57 УБО	МЦУ 2000	10	1		Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
2	2025.08.14		МЦУ 2000	12	1	1	Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
3	2025.09.07		МЦУ 2000	12	1	1	Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
4	2025.10.25	43-99 УНЧ	МЦУ 2000	12	1	1	Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
5	2025.10.01		МЦУ 2000	12	1		Ди Зэт Энд Ай ХХК-ийн ажилласан тос масло түр цуглуулах цэгт
			Нийт	58	5	3	

Ди Зэт Энд Ай ХХК-ийн Толгойтын уурхай нь ажилласан тос маслыг 1тн-ын 3-н ёмкость хүлээн авч цуглуулан, “Үлэмж хүдэр” ХХК-д гэрээгээр нийлүүлдэг.





Зураг- 17 Ди Зэт Энд Ай ХХК-ийн Толгойтын уурхайн ажилласан тос масло түр хадгалах цэг

1. Уурхайн кемп орчмын хог хаягдлыг тогтсон нэг цэгт ангилан ялгаж, төвлөрүүлэх зорилгоор төмөр суурьтай, салхинд хийсэхээс сэргийлсэн дээвэр бүхий хаалттай хогийн савыг хаягдал төмрийг дахин ашиглаж хийсэн. Түр хогийн цэгээс хог хаягдал ус, салхиар зөөгдөх, шүүрэл ялгарч хөрсөнд нэвчихээс сэргийлэн, төмөр суурьтай, тасалгаатай, хог хаягдал салхинд хийсэх, нохой, шувуу орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор дээвэр бүхий хаалттай түр хогийн цэгийг байгуулан ажиллаж байна. Төслөөс гарах дахин ашиглах ангилан ялгасан хог хаягдал, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг “Үлэмж хүдэр” ХХК-тай хийсэн гэрээний дагуу хог хаягдлыг тээвэрлүүлэн, нэгдсэн хогийн цэгт зайлуулж ажилласан.



Зураг- 18 Үлэмж Хүдэр ХХК-ийн Сарлаг толгой дахь үйлдвэр

2. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглахын ач холбогдол сэдэвт мэдлэг, мэдээлэл олгох сургалтыг Толгойтын уурхайн нийт ажилчдад орж ажилласан. Ил задгай хог хаяхгүй байх талаар анхааруулга санамж бүхий самбарыг шаардлагатай цэгт байршуулсан.



Зураг- 19 Хог хаягдал ангилан ялгах хогийн сав хийж байгаа болон хийсний дараах байдал.

3. Төслийн хэмжээнд Толгойтын уурхайн бүсэд их цэвэрлэгээг батлагдсан хуваарийн дагуу буюу сар бүрийн лхагва гарагт батлагдсан талбайд хийж, дараагийн ээлжинд цэвэрлэсэн талбайг хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулж ажилладаг. Мөн ил задгай хог хаягдал хаяхгүй байх санамж бүхий самбарыг автомашины зогсоол болон уурхайн талбайд байршуулав.

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ОХШХ-ийн зорилго нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд тусгагдсанаар БОХТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих, төсөл хэрэгжих талбайн нөлөөллийн бүсийн өөрчлөлт, сөрөг нөлөөллийг олж илрүүлж, орчны хяналт шинжилгээний дүнд хариу арга хэмжээ авч, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад оршино.

Тайлант онд агаарын нийт тоос, Толгойтын голын усны болон ундны усны гол ион, биогений элемент, хөрсний агрохимийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлсэн. Эдгээр шинжилгээг 7,8,9 дүгээр саруудад зохион байгуулж Байгаль орчны суурь судалгааны төв болон Сэлэнгэ аймгийн УЦУОШГ-аар хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан.



Зураг- 20 Орчны хяналт шинжилгээ, агаар, усны дээж авч байгаа нь

Агаар орчны шинжилгээ:

Хүснэгт-9.1 Агаарын шинжилгээний дүн 8-н сар.

Огноо	Хэмжилт хийсэн цэгийн нэр	Хэмжих нэгж мг/м ³		
		Нийт тоос		
		Дундаж	Хамгийн бага	Хамгийн их
2025.08.26	Уурхайн зам	0.014	0.007	0.185
	Элс угааж буй угаах төхөөрөмж	0.018	0.014	0.044
MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж		0.500		

СУЦУОШГ-аас “Ди Зэт Энд Ай” ХХК-ийн Толгойтын уурхайд агаарын дээж авч химийн шинжилгээ хийснээс MNS 4585:2016 стандарт дахь хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт илрээгүй. Бид агаарын тоосжилтоос урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд уурхайн технологийн зам усалгааны ажлыг тогтмол хийх зорилго тавин ажиллаж байна.

Усан орчны шинжилгээ:



График 7 Унд ахуйн худгийн шинжилгээний дүн /Уурхайн ажиллагсдын кэмийн худга/.

Толгойтын уурхайн ундны усны шинжилгээг хийлгэхэд MNS 0900:2018 стандартын ЗДХ-ээс давсан үзүүлэлт байхгүй байна.





График 8 Толгойтын голын шинжилгээний дүн.

Толгойтын голын усны химийн шинжилгээний үр дүнд сульфат МУ-ын стандарт хэмжээнд , хатуулаг хэвийн байна. Усны хатуулаг энэ бүс нутагт нийтлэг, байгалийн зохилдлогоотой бөгөөд сульфат хэвийн хэмжээнд байна.Голын усанд агуулагдах

сульфатын хэмжээ хэвийн байгаа нь Ди Зэт Энд Ай ХХК-ны уурхайгаас нөлөөлсөн зүлгүй гэж үзэж байна. энгийн нүдээр харж таних боломжтой ба голын эргэн тойрны хөрс улаан өнгөтэй байна (1). Зарим голын усанд агуулагдах сульфатын агууламж гадаргын усны нэмэгдэл (гүний ус гадагшлах) эсвэл алдагдлаас (гүний ус дахин цэнэглэгдэх, нэвчих) хамаарч болно. Гүний усны гадагшлах эсвэл нэвчих процессын үед газрын доорх уст давхаргад ус хэр удсанаас усанд агуулагдах минералын бүрдлүүд хамаарна. Гүний усны дахин цэнэглэгдэх буюу нэвчих процессын үед гүний усны найрлага дахь Ca-Mg HCO_3 болон CaSO_4 (хуурай уур амьсгалтай оронд элбэг тохиолддог) ердийн уст давхаргад агуулагдах NaSO_4 -тай урвалд орж Na-HCO_3 болон NaCl агуулсан ус болно. Эдгээр гидрохимийн процесс нь үндсэндээ хязгаарлагдмал бус, хязгаарлагдмал, хагас хязгаарлагдмал уст давхарга доторх катионы солилцоо, бактериас улбаалж явагддаг процесс юм.



Зураг- 21 Уст давхаргуудын анион катионы солилцооноос улбаалж голын усны найрлагад өөрчлөлт ордог болохыг үзүүлэв.

Хөрсний шинжилгээ:

Хүснэгт-9.5. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн.

Дээж авсан цэгийн нэр	Тодорхойлсон элементүүд (хэмжих нэгж) мг/кг						Ариун цэврийн үнэлгээ
	<i>РН</i>	<i>Сульфат</i>	<i>Нитрат</i>	<i>Фосфор</i>	<i>Аммоний Азот</i>	<i>Ялзмаг %</i>	
<i>Карьер орчмоос</i>	7.95	52.0	10.12	157.04	25.21	2.00	
<i>Хогийн цэг</i>	8.1	80.1	15.23	193.71	101.1	1.00	Цэвэр
<i>Стандарт 3297:2019</i>		160	130				

Толгойтын уурхайн хөрсний хяналтын 4 цэгт агрохимийн шинжилгээ хийлгэв. Шинжилгээний дүнгээс хяналтын 1-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-21 см-ийн гүнд 3,63 %, Урвалын орчин рН 7.25 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (EC2.5) 29.9 dS/m дунд зэргийн давсжилтай, хяналтын 2-р цэгт Хөрсний ялзмагийн агууламж 0-18 см-ийн гүнд 2,75 %, Урвалын орчин рН 7.25 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (EC2.5) 25.1 dS/m буюу дунд зэргийн давсжилтай, хяналтын 3-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-16 см-ийн гүнд 3 %, Урвалын орчин рН 7.22 буюу саармаг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (EC2.5) 28.4 dS/m буюу дунд зэргийн давсжилтай, хяналтын 4-р цэгт хөрсний ялзмагийн агууламж 0-15 см-ийн гүнд 2.6 %, урвалын орчин рН 7.35 буюу сул шүлтлэг шинжтэй, цахилгаан дамжуулах чанар (EC2.5) 3 dS/m дунд зэргийн давсжилтай шинжийг тус тус үзүүлсэн байна.

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

1. Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэн зөрчил дутагдлыг илрүүлэн арилгах, бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байсан .
2. Толгойтын уурхайн хүрээнд БО-ы инженерийг нэмэгдүүлсэн
3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 болон байгаль орчны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу байгаль орчны аудитыг “Өртөөлөн ” ХХК Байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллагаар хийлгэж ажиллалаа.

Байгаль орчны аудитын үйл ажиллагааны хүрээнд 7 чиглэлээр 95 шалгуур үзүүлэлтийг гарган үнэлэхэд нийт шалгуур үзүүлэлтүүдийн:

- 83 нь биелсэн /87.4%/
- 9 нь бүрэн бус /9.5%/
- 3 нь биелээгүй /3.2%/ ангиллаар нотлогдон гарсан байна.

Өөрөөр хэлбэл, Толгойтын уурхай нь хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хүлээх үүргээ 92% буюу сайн үнэлгээтэй биелүүлж байна. Аудитын үнэлгээгээр бүрэн бус шалгуурууд буюу үл тохиролд эрсдлийн үнэлгээ хийж үзэхэд 2 нь бага эрсдэлтэй, 6 нь дунд эрсдэлтэй, 3 нь их эрсдэлтэй гарсан байна.

АРВАН НЭГ.АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ:

Нутгийн олон нийтийн төлөөлөлд 2025 оны 10 дугаар сард Уурхайн нөхөн сэргээлт хийсэн талбайг үзүүлж тайлагнасан. Мөн багийн ИНХ-д 2025 оны байгаль орчны менежментийн тайлан болон 2025оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулсан болно.

Мөн оны 10-р сард Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газрын мэргэжилтэн Ойн газрын мэргэжилтэнүүд төслийн талбайд ирж ажилласан.

2025 оны нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт нь олборлолтын үйл ажиллагаа явагдсаны дараа нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

Ажилчдын аюулгүй байдлыг хангах:

- Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг болон бусад

байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулж ажиллаж байна. Мөн уурхай дээр байнгын эмчийг ажиллуулж ажиллагсадад шаардлагатай эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлж байна.

**ТОЛГОЙТЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНД ЗАРЦУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ, ЗАРДЛЫН
ЗАДАРГАА.**

Д/Д	Байгаль орчны бүрдэл хэсэг	Төвлөгөөгөөр /сая.төг/	Биелэлтээр зардал /сая.төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3.195	5.362
2	Нөхөн сэргээлт	12.0	8.0
3	Дүйцүүлэн хамгаалалт	13.7	103.3
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох	-	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
6	Осол эрсдлийн менежментийнм төлөвлөгөө	1.0	1.2
7	Хог хаягдлын менежмент	3.1	4.2
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1.7	0.38
9	Удирдлага зохион байгуулалт	2.5	8.0
10	БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	2.0	1.2
Нийт		39.195	131.62